



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2023 оны 01 дугаар сарын 16

№ 06/03

Улаанбаатар хот

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
ТАНАА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.11, 18 дугаар зүйлийн 18.1.1, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн "Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн ажилчдын хөдөлмөр эрхлэх эрх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилт, Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх, "Төрийн байгууллагуудын барилга байгууламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй эсэх", "Төрийн захиргааны байгууллагуудад Ахмадын сан байгуулсан эсэх", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 437 дугаар нээлттэй хорих ангийн "Цагдан хорих байр"-ны үйл ажиллагаатай танилцаж хоригдож буй хүний Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд 2022 оны 10 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд тус тус хяналт шалгалт хийсэн.

Хяналт шалгалтыг дээрх байгууллагуудын удирдлага, ажлын алба, албан хаагчдын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын талаар амаар болон бичгээр тайлбар авах, дуу, дүрсний болон техникийн хэрэгсэл ашиглах, холбогдох баримт бичгийг гаргуулан авч, газар дээр нь танилцах, баримтжуулах, хуулбарлан авч дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

Нэг. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт "ажил олгогч нь ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, дарамт хүчирхийллийг таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгаж, уг гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй" гэж тус тус заасан байна. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, мөн зүйлийн 11.7 дахь хэсэгт "ажил олгогч ажлын байранд бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээ болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаарх ажил олгогч, ажилтны эрх, үүргийг хөдөлмөрийн дотоод журамд тусгана" гэж заажээ. Комиссоос тус төвийн дотоод хэм хэмжээг зохицуулж буй бичиг баримтад дүн шинжилгээ хийж үзэхэд Хөдөлмөрийн дотоод журманд энэ талын зохицуулалт тусгагдаагүй байна.

2. Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт "Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна", мөн хуулийн 48 дугаар

D:\2023 on\A4.month1.docx

150060081

зүйлийн 48.1 дэх хэсэгт "Ажил олгогч хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурах бөгөөд гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй" гэж тус тус заасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ажилтнуудын хөдөлмөрийн гэрээнээс түүвэрлэн 49 гэрээтэй танилцахад гэрээний дугаарлалт хийгдээгүй, долоон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд ажилтан танилцаж гарын үсэг зурж баталгаажуулаагүй зөрчил байна.

3. Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтад "хамтын гэрээ" гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог" хэлнэ гэж тодорхойлсон байна. Үйлдвэрчний эвлэлийн хороо, ажил олгогч хоёрын харилцан тохиролцсон хамтын гэрээний зургадугаар бүлгийн 6.15-д "Ажилтнуудыг 2022 оны 3 дугаар улирлаас эхлэн халуун хоолоор хямдралтай үнээр хангана" гэж заажээ. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн ажилтны төлөөлөлтэй хийсэн ярилцлагад "... эмнэлгийн ажилтнуудад хоолны мөнгө олгодоггүй, жижүүрийн эмчид халуун хоолоор үйлчилж, бусад жижүүрийн ээлжид хонож байгаа сувилагч, асрагч, эмнэлгийн ажилтнуудыг хоол ундаар хангадаггүй талаар онцлон хэлж байсан. Мөн тус төвийн Үйлдвэрчний эвлэлийн хороо ажил олгогчтой байгуулсан хамтын гэрээгээр хүлээсэн тохиролцооны хүрээнд нийт эмч, эмнэлгийн ажилтнуудыг халуун хоолоор хөнгөлөлтэй үнээр хангах, ээлжид гарч буй сувилагч, асрагч, эмнэлгийн ажилтанд халуун хоолоор үйлчлэх талаар саналыг ажил олгогчид хүргүүлж байсан боловч үр дүнд хүрээгүй байна.

4. "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" стандарт "MNS5095:2017"-д Сэргээн засах эмчилгээний тасаг нь цахилгаан эмчилгээ, гэрэл эмчилгээ, биеийн тамир эмчилгээ, усан эмчилгээ, шавар эмчилгээ, уламжлалт эмчилгээ үзүүлнэ гэж заасан. Тус төвийн Сэргээн засах эмчилгээний тасгаар үйлчлүүлж буй иргэдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагад "... Сэргээн засах эмчилгээний тасгийн эмч, эмнэлгийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах шаардлагатай, зарим эмийн олдоц муу, хавар болохоор боклопин эм олддоггүй, жилдээ 3-4 удаа хэвтэн эмчлүүлдэг, хүүхдийн тасгийн тусламж үйлчилгээ сайн байдаг, энэ эмнэлэгт хүүхдийн мэргэжлийн мэдрэлийн эмч байхгүй, заавал хот руу явж Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвд очиж үзүүлдэг" гэх асуудлуудыг дурдаж байсан. Мөн эмнэлгийн ажилтны төлөөлөлтэй хийсэн ярилцлагад "... тасгийн эмч, эмнэлгийн ажилтны орон тоо дутуу байгаагаас усан болон шавар эмчилгээг иргэдэд үзүүлэхгүй байгаа" гэх тайлбарыг өгч байсан. Дээрх ярилцлагаас үзэхэд нэг эмч, сувилагчид оногдох өвчтөний тоо, ажлын ачааллаас үүдэн үр дүнтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байгаа байдал үүссэн гэж үзэхээр байна.

5. Комиссоос авсан санал асуулгад нийт 125 ажилтан хамрагдсанаас 17 хувь нь удирдлагын зүгээс үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, боловсрол, шашин шүтлэг, үзэл бодол болон бусад байдлаар ялгаварлан гадуурхаж харьцдаг гэж, 68.9 хувь нь хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтын талаар мэдлэг олгоход чиглэсэн сургалт зохион байгуулдаггүй тул ийм төрлийн сургалт шаардлагатай гэж тус тус хариулжээ.

6. Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалтад "иргэн эмч, эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах эрхийг эдэлнэ", Сэтгэцийн эрүүл

мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтад “Сэтгэцийн эмгэгтэй хүн сэтгэцийн эрүүл мэндийн болон эмнэлгийн шаардлагатай үйлчилгээ авах, асран халамжлуулах” эрхтэй гэж тус тус заасан. Тус төвд хэвтэн эмчлүүлж байсан өвчтнүүдийн төлөөлөлтэй ярилцахад “Сэтгэцийн эмгэгтэй болон архинд донтох эмгэгтэй өвчтнийг дотрын нарийн мэргэжлийн тасаг руу шилжүүлэх, эмчилгээ үйлчилгээ авахад хүндрэл үүсдэг, хүлээж авдаггүй, өвчнүүдийг ялгаварлан гадуурхах асуудал үүсгэдэг” талаар ярьж байсан зэргээс үзэхэд тэдэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг хангалттай хэмжээнд үзүүлдэггүй байж болзошгүй байна.

7. Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Сэтгэцийн эмгэгтэй хүнийг хэвтүүлэн эмчлэх эмнэлгийн орчин нь эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан, сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдлыг хангахуйц нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж тус тус заасан. Сэтгэцийн тасагт харуул хамгаалалтын ажилтан байхгүй байгаа нь эмчлүүлэгчийн зүгээс өөрийн болон бусдын амь бие, эрүүл мэндэд халдах нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн хяналт шалгалтын талаар:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчин бүрдүүлсэн эсэх талаар Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар /Нутгийн удирдлагын ордон/, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Татварын хэлтэс, Прокурорын газар, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүүхэд, залуучуудын театр, Залуучуудын ордон, Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Уурхайчин спортын цогцолбор, Хаан банк, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Есөн эрдэнэ худалдааны төв зэрэг 32 байгууллага хамрагдсанаас налуу замыг стандартад нийцүүлсэн 14 байгууллага, стандартын бус налуу замтай 15, налуу зам байхгүй 2 байгууллага, налуу зам нь бариултай 14 байгууллага, бариул байхгүй 15 байгууллага, хүлээлгийн сандалтай 14 байгууллага, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээллийг зайлшгүй хүлээн авах өрөө тасалгаатай байгууллага байхгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан таних тэмдэг, тэмдэглэгээтэй 14 байгууллага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөндөө зориулалтын бариултай 1 байгууллага, байгууллагын доторх өрөө тасалгааны хаалга стандартын буюу 85-аас дээш см хаалгатай 28 байгууллага байна. Хаалганы босго 2.5 см-тай 28 байгууллага түүнээс дээш хэмжээтэй 4 байгууллага, байгууллагын гадаа хаалганы өргөн 85-аас дээш см хэмжээтэй 28 байгууллага байгаа нь тус аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлээгүй байна гэж үзсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 9 дүгээр зүйлийн 9.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх байдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад тотгорыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг авна” гэж, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Орон сууц, олон нийтийн барилга, байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна”, Барилгын

тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д “Барилгын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөгдөн баригдсан байх зарчмыг баримтална” гэж тус тус заасан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш хамруулах шаардлагыг MNS 6055:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлагыг тооцсон орон зайн, орчин, Үндсэн шаардлага”, MNS 6056:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, MNS 5682:2006 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зам, Техникийн шаардлага”-д тус тус заажээ.

Гурав. Ахмадын сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын талаар:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар, Соёл, урлагийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газрын “Ахмадын сан”-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Уг шалгалтаар Боловсрол, шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж “Ахмадын сан” байгуулж данс нээсэн байна. Төрийн байгууллагуудаас төлөөлөл болгон дээрх 5 байгууллагыг шалгахад 3 байгууллага нь Ахмадын сан байгуулаагүй байгаа нь тус сангийн үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжиж байна гэж үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3-т “аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настныг дэмжих талаар авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, энэ талаарх хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ахмад настныг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах”, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам”-д тус тус заасан.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоор баталгаажсан “өндөр наслах, ... хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах” зэрэг ахмад настны хөгжих, хамгаалуулах эрх хангагдаагүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дугаар зүйлийн 7-д “Монгол Улсын Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах...”, “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-д “Аймгийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцна” гэж заасныг тус тус удирдлага болгон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн дагуу дараах Шаардлагыг хүргүүлж байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвд

1. Ажилтнуудад халуун хоолоор хөнгөлөлтэй үнээр үйлчлэх, тэдэнд хоолны мөнгө олгох асуудлыг шийдвэрлэх;
2. Сэргээн засах эмчилгээний тасгийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж орон тоог нэмэгдүүлэх, Усан болон Шавар эмчилгээ үйлчилгээ үзүүлэх

- боломж нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн мэдрэлийн нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтны хүний нөөцийг хангах асуудлыг бодлогоор дэмжих;
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орчны хүртээмжийг бий болгож зориулалтын ариун цэврийн болон угаалтуурын өрөөтэй болох, нярай хүүхэдтэй ээжүүд хүүхдээ хуурайлах, хөхүүлэх өрөө тасалгааг бий болгож орчин нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
 4. Эмч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан хүний эрхийн болон хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн мэдлэг олгох хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
 5. Сэтгэцийн эмгэгтэй болон архинд донтох эмгэгтэй өвчтнүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах;
 6. Сэтгэцийн тасгийг харуул хамгаалалттай болгож, эмч, эмнэлгийн ажилтан, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зэрэг арга хэмжээг Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заагдсан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх чиглэлээр

1. Аймгийн хэмжээнд нийтийн тээвэр, албан газар, олон нийтийн үйлчилгээний газар, орон сууц, гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан стандарт мөрдөгдөж байгаа эсэхэд үзлэг хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж ажиллах;
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тэгш хамруулах, хүрэлцээтэй байх орчин нөхцөл бүрдүүлээгүй аж ахуй нэгж байгууллагын барилга байгууламжийг холбогдох стандартад нийцүүлэх, цаашид стандартад нийцээгүй барилга байгууламж, зам талбайг хүлээн авч, ашиглалтад оруулахгүй байх шийдвэрийг гаргаж холбогдох албан тушаалтан, аж ахуй нэгж, олон нийтэд танилцуулах;

Ахмад настны эрхийн чиглэлээр

1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах тухай журам"-д заасны дагуу төрийн захиргааны байгууллагуудад ахмадын сан байгуулах арга хэмжээ авч, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан бөгөөд Шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн талаар нотлох баримтын хамт мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт ¹¹ хуудастай.

ГИШҮҮН


Б.ЭНХБОЛД




ОРХОН АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРЧНЫ ХҮРТЭЭМЖИЙГ БИЙ БОЛГОСОН БАЙДАЛ

Д/д	Зургийн тайлбар	Зураг
1.	Нутгийн удирдлагын ордын үүдний хэсэг	
2.	Төрийн захиргааны 2 дугаар байрны үүдний хэсэг	

3.

Төрийн
захиргааны 3-р
байрны дотор
болон гадна
үүдний хэсэг



<p>4. Баян-Өндөр сумын ЗДТГазар, Улсын бүртгэлийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын гадна үүдний хэсэг</p>	
<p>5. Нийгмийн даатгал, Татварын хэлтсийн гадна үүдний хэсэг</p>	
<p>6. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын гадна үүдний хэсэг</p>	

7.	<p>Нэг цонхны үйлчилгээний төвийн гадна үүдний хэсэг</p>	
8.	<p>Шүүхийн гадна үүдний хэсэг</p>	
9.	<p>Прокурорын байгууллагын гадна үүдний хэсэг</p>	

<p>10.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гадна үүдний хэсэг</p>				
<p>11.</p>	<p>Цагдаагийн газрын гадна үүдний хэсэг</p>				
<p>12.</p>	<p>Замын цагдаагийн газрын гадна үүдний хэсэг</p>				

13.

Гэр бүл, хүүхэд
хөгжлийн газрын
гадна үүдний хэсэг





14.

Гэр бүлийн ордны
гадна үүдний хэсэг



15.	Залуучуудын ордны гадна үүдний хэсэг		
16.	Өргөө кино театрын гадна үүдний хэсэг		 
17.	Хүүхэд, Залуучуудын театрын гадна үүдний хэсэг		

18.	МУИС-ийн Эрдэнэт хотын салбар сургуулийн гадна үүдний хэсэг	
19.	Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн үүдний гадна хэсэг	
20.	Уурхайчин соёл, урлагийн цогцолборын гадна үүдний хэсэг	

21.	Уурхайчин спортын цогцолборын гадна үүдний хэсэг	
22.	Хаан банкны гадна үүдний хэсэг	
23.	Төрийн банкны гадна үүдний хэсэг	

24.	Төрийн банкны салбаруудын гадна үүдний хэсэг	
25.	Худалдаа хөгжлийн банкны гадна үүдний хэсэг	
26.	Хүлэг захын гадна үүдний хэсэг	

27.	<p>Есөн эрдэнэ худалдааны төвийн гадна үүдний хэсэг</p>			
28.	<p>Худалдааны төвийн гадна үүдний хэсэг</p>			